



ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2013 оны 10 сарын 25 өдөр

Дугаар A/567

Эрдэнэт

Журам батлах тухай

Монгол улсын Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 21 дүгээр зүйл, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 10 дугаар зүйл, Аймгийн Засаг дарга бөгөөд Эрдэнэт хотын Захирагчийн 2013-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний 1.1.3 дугаар зүйлийн 1.1.3.3 дахь заалтыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1."Худалдан авах ажиллагааг олон нийтэд ил тод мэдээлэх журам"-ыг хавсралтаар баталсугай.

2.Дээрх журмыг мөрдөж, хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Худалдан авах ажиллагааны алба /н.Оюунгэрэл/, Баян-Өндөр сумын Засаг дарга И.Баасанжав, Жаргалант сумын Засаг дарга С.Дангаасүрэн нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЗОРИГТ

Аймгийн Засаг даргын 2013 оны 10 дугаар сарын
25 ны өдрийн 567 дугаар захирамжийн хавсралт

ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААГ ОЛОН НИЙТЭД ИЛ ТОД МЭДЭЭЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь Худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангахдаа “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль” болон “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль” –ийг дагаж мөрдөнө.

1.3. Энэ журамд заасан Худалдан авах ажиллагааны талаархи ил тод байдалтай холбогдсон зохицуулалт нь хууль тогтоомжийн дагуу төрийн нууцад хамаарах, Улсын аюулгүй байдлыг хангах эрх бүхий байгууллагын үйл ажиллагаанд хамаарахгүй.

Хоёр. Худалдан авах ажиллагааны мэдээллийг олон нийтэд түгээхэд баримтлах зарчим

2.1. Худалдан авах ажиллагааны мэдээллийн ил тод байдлыг хангахад дараах зарчмыг баримтална.

2.1.1. Хуулийн дагуу нууцад хамааруулснаас бусад бүх мэдээлэл ил тод, нээлттэй байх;

2.1.2. Шударга, тэгш өрсөлдөх боломж олгох

2.1.3. Үр ашигтай, хэмнэлттэй байх

2.1.4. Хараат бус байх

2.1.5. Мэдээллээр хангах үйл ажиллагаа шуурхай байх.

Гурав. Мэдээллийн бүтэц

3.1. Худалдан авах ажиллагааны мэдээлэл дараах бүтэцтэй байна.

3.1.1. Худалдан авах ажиллагааны холбогдолтой хууль, эрх бүхий байгууллагаас батлан гаргасан журам заавар, Тендерийн жишиг баримт бичгийн загварыг мэдээлэх

3.1.2. Аймгийн Засаг даргаар батлуулсан Худалдан авах ажиллагааны жилийн төлөвлөгөө, түүний тодотгол, өөрчлөлтийг мэдээлэх

3.1.3. Нээлттэй тендерийн урилгыг олон нийтэд ил тод зарлан мэдээлэх. Тендерийн урилгад дараах мэдээллийг тусгаж мэдээлнэ.

3.1.3.1. Захиалагч байгууллагын тодорхойлолт

3.1.3.2. Худалдаж авах бараа, ажил, үйлчилгээний товч агуулга

3.1.3.3. Тендерийн баримт бичиг, бусад мэдээлэл авах, тендер ирүүлэх

хаяг

- 3.1.3.4. Тендерийн баримт бичгийн үнэ
- 3.1.3.5. Тендер шалгаруулалтад тавих тусгай шаардлага
- 3.1.3.6. Тендер хүлээн авах эцсийн хугацаа
- 3.1.3.7. Тендер нээх хугацаа
- 3.1.3.8. Гадаадын этгээдийг оролцуулах эсэх
- 3.1.3.9. Давуу эрх олгох эсэх

3.1.4. Тендерт оролцогчдын шалгарсан үндэслэл болон шалгараагүй шалтгаан, нөхцөл, хуулийн үндэслэлийн талаар мэдээлэх

3.1.5. Худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний улирал, жилийн тайланг мэдээлэх

3.1.6. Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт, шалгалтын дүнг тухай бүр мэдээлэх

Дөрөв. Мэдээллийг олон нийтэд хүргэх арга хэлбэр

4.1. Худалдан авах ажиллагааны мэдээллийг олон нийтэд хүргэхдээ Худалдан авах ажиллагааны албаны болон Аймгийн ЗДТГ-ын мэдээллийн самбар, орон нутгийн телевиз, сонин хэвлэл, цахим сайтуудаар мэдээлнэ.

4.2. Цахим сайт болон мэдээллийн бусад хэрэгсэл ашиглаж байгаагаас үл хамааран Худалдан авах ажиллагааны албаны мэдээллийн самбарыг тогтмол ажиллуулна.

4.3. Тендер оролцогч, иргэд мэдээллийн самбарт байршуулсан мэдээллийг дэлгэрүүлж авах тохиолдолд тэрхүү мэдээллийг ямар эх сурвалжаас олж авахыг тодорхой заасан байна.

Тав. Хариуцлага

5.1. Худалдан авах ажиллагааны мэдээллийг олон нийтэд ил тод мэдээлэх ажлыг Аймгийн Худалдан авах ажиллагааны албаны мэдээлэл, сурталчилгаа хариуцсан ажилтан, Баян-Өндөр, Жаргалант сумдын ЗДТГын дарга нар, аймаг, сумдын ЗДТГ-ын вэб сайт /цахим хуудас/ хариуцсан ажилтан хариуцан ажиллана.

5.2. Энэхүү журмын биелэлтэнд Аймгийн Худалдан авах ажиллагааны албаны дарга, Сумдын Засаг дарга нар хяналт тавьж ажиллана.

5.3. Энэхүү журмыг зөрчсөн албан тушаалтанд Төрийн албаны хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.